


“Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ стратегийн төлөвлөгөө 2020-2023 он

“Өсвөр үе хүнс” ОНӨААТҮГ-ын захирлын
2019 оны 11 дүгээр сарын 28-ний өдрийн
1/24 дугаар тушаалын хавсралт



**“Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ-ын 2020-2023 оны Стратегийн
төлөвлөгөөний агуулга**

Танилцуулга

- 1. Стратегийн үндсэн зорилтууд**
- 2. Байгууллагын бүтэц, зохион байгуулалт**
- 3. Худалдан авах ба нийлүүлэх бүтээгдэхүүн**
 - 3.1 Нийлүүлэх бүтээгдэхүүн
 - 3.2 Худалдан авах болон нийлүүлэх бүтээгдэхүүнд тавигдах шаардлага
- 4. Зах зээлийн судалгаа**
 - 4.1 Хэрэглэгчийн судалгаа
 - 4.2 Бэлтгэн нийлүүлэгчийн судалгаа
 - 4.3 Бүтээгдэхүүний орц нормын судалгаа
- 5. Маркетингийн төлөвлөгөө**
 - 5.1 Маркетингийн стратеги
 - 5.2 Бүтээгдэхүүний бодлого
 - 5.3 Үнийн бодлого
 - 5.4 Борлуулалтын төлөвлөгөө
 - 5.5 Хяналтын механизм

“ӨСВӨР ҮЕ ХҮНС”
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Байгууллагын товч түүх: БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1979 оны 389-р тогтоолыг үндэслэн Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа, Ардын Боловсролын Яам, Сангийн Яамны шийдвэрээр 1980 оны 07 дугаар сарын нэгнээс Улаанбаатар хотын бүх дүүрэгт сургууль, цэцэрлэгүүдийн нэгдсэн аж ахуй нэртэй байгууллагууд байгуулагдан ажиллаж эхэлсэн байна.

Улмаар дээрх байгууллагууд Үндсэн хууль ба аж ахуйн нэгжийн шинэчилсэн хуулийн дагуу бүтэц зохион байгуулалтын хувьд өөрчлөгдөж 1992 оноос улсын өмчит үйлдвэрийн газар, 2000 оноос нийслэлийн өмчит үйлдвэрийн газар, 2015 оноос орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын статустайгаар ажиллаж эхэлсэн.

2006 онд тухайн байгууллагуудын үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөж, хоёр дүүргийн дунд нэг хангамжийн байгууллага ажиллуулахаар НИТХ-аас тогтоол гарч, улмаар Хан-Уул дүүрэгт ажиллаж байсан “Хан-Уул Хангамж”, Баянзүрх дүүрэгт ажиллаж байсан “Балчирхан” Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг нэгтгэж “Өсвөр Үе Хүнс” Нийслэлийн Өмчит Үйлдвэрийн газрыг байгуулсан түүхтэй.

“Өсвөр Үе Хүнс” Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар нь НИТХТ-дийн 2006 оны 06-р сарын 21-ний өдрийн 154 тоот тогтоолоор Баянзүрх, Хан-Уул дүүргийн 42- цэцэрлэг 2 яслийн хүүхэд багачуудыг өдөр тутмын хэрэгцээт хоол хүнсээр тасралтгүй хангах ажлыг зохион байгуулах үндсэн үүрэгтэйгээр 2006 оны 07-р сарын 01-ний өдөр байгуулагдсан. Тус НӨҮГ нь тухайн үедээ 32.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэйгээр байгуулагдсан ба одоогоор 434.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байна.

Байрлал: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 19-р хороо, 16-р хороололд байрлах өөрийн байгууллагын байранд.

Хуулийн этгээдийн эрх зүйн байдал: Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар 9014001010, регистрийн дугаар 5056837

Үйл ажиллагааны чиглэл: Баянзүрх дүүргийн 42 цэцэрлэг, 1 ясли, Хан-Уул дүүргийн 28 цэцэрлэг, 1 ясли, Багахангай дүүргийн 2 цэцэрлэг, нийт 72 цэцэрлэг, 2 ясли, 26000 орчим хүүхэд багачуудыг өдөр тутмын хэрэгцээт хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээр захиалгын дагуу тасралтгүй хангах үндсэн үүрэгтэй ажилладаг.

Байгууллагын давуу тал: Зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн тогтвортой харьцаа, шинжилгээ баталгаажилттай, чанартай бүтээгдэхүүн нийлүүлдэг найдвартай харилцагч түншүүд, санхүүгийн баталгаатай эх үүсвэр.

Байгууллагын сул тал: Санхүүжилтийн хувьд үйлчлүүлэгчийн эдийн засгийн боломж хязгаарлагдмал, санхүүгийн чадавхи сул, түншүүдийн итгэлцэл, зээлийн тогтолцоонд тулгуурлан үйл ажиллагаа явагддаг. Түүхий эд, бүтээгдэхүүний зах зээлийн үнэ тогтворгүй.

1. СТРАТЕГИЙН ҮНДСЭН ЗОРИЛТУУД

Байгууллагын эрхэм зорилго

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагыг эрүүл ахуйн шаардлага хангасан чанартай, баталгаажсан, эрүүл хүнсээр тогтвортой, тасралтгүй хангах, хүнсний аюулгүй байдлыг хангаж, хурдан шуурхай үйлчлэхэд оршино.

2020-2023 онд цэцэрлэг, яслийн хүнсний хангамжийн зах зээлд хангалт, нийлүүлэлтээрээ өөрийн нэр хүнд, байр суурийг бий болгон хүнсний хангамжийн аж ахуйн оновчтой иж бүрэн системийг зохион байгуулж чадавхиа сайжруулан, хүнсний аюулгүй байдлыг хангах төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг тэргүүлэгч байгууллага болох.

Дүрмээр хүлээсэн үүргийн дагуу Баянзүрх, Хан-Уул, Багахангай дүүргүүдэд шинээр үйл ажиллагаагаа эхлүүлж байгаа төрийн өмчийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудыг бүрэн хүчин чадлаараа хүнсний бүтээгдэхүүнээр хангаж ажиллах

Эдгээр зорилгыг хэрэгжүүлэх үүднээс дараах зорилтуудыг дэвшүүлнэ.

Стратеги-Байгууллагын хүнсний агуулахын барилгыг хангамжийн байгууллагын стандартад нийцүүлэн шинэчлэх, өргөтгөх

- Өөрийн ашиглаж байгаа агуулах, оффисын актлагдсан барилгыг шинэчлэх үүднээс барилгын зураг төслийг батлуулах, цаашид барилга барих хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэх, барилгын ажлыг гүйцэтгүүлж, ашиглалтад оруулах.
- Стандартад нийцсэн агуулахын хадгалалт, түгээлтийн аж ахуйн үйл ажиллагааг чанарын өндөр түвшинд зохион байгуулах

Стратеги-Үндсэн үйл ажиллагаа, үйлдвэрлэл технологийн хувьд

- Хан-Уул, Баянзүрх, Багахангай дүүргийн цэцэрлэгүүдийг хүүхдийн хоолны норм, үндсэн шимт бодисын илчлэгийн хэрэгцээ, эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнээр тасралтгүй хангах.
- Цэцэрлэгийн хүүхдийн хүнсэнд хэрэглэж байгаа бараа бүтээгдэхүүний дийлэнх хувийг үндэсний үйлдвэрлэгчдийн хүнсний бүтээгдэхүүнээр хангах.
- Цэцэрлэгийн хүүхдийн хүнсний ногооны хэрэгцээг эх орны хөрсөнд тарьсан бүтээгдэхүүнээр хангах.
- Цэцэрлэгийн хүүхдийн сүү, сүүн бүтээгдэхүүнийг 100 хувь үндэсний үйлдвэрлэгчдээс хангах.
- Цэцэрлэгүүдэд хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ, ханшийн өсөлтийг барьж, тогтвортой үнээр нийлүүлэх.
- Санхүүгийн болон бүтээгдэхүүний гэнэтийн хомсдолын үед давж гарах бараа бүтээгдэхүүний байнгын нөөцтэй байх, шаардлагатай үед мах, гурил, будаа, хүнсний ногоо зэрэг стратегийн хүнсний нөөц бий болгож ажиллах.
- Түргэн муудах зарим нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон цэцэрлэгүүдтэй гурвалсан гэрээ байгуулж үйлдвэрээс нь шууд хүргэлт хийлгэх.

- Гэрээт байгууллагуудаас баталгаажсан эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүн татан авах
- Бараа бүтээгдэхүүнийг чанар стандартын шаардлага хангасан зориулалтын газар хадгалах
- Агуулахаас бараа бүтээгдэхүүнийг зөв оновчтой хуваарилж жигд хүрэлцээтэй захиалгын дагуу гаргах
- Хуваарийн дагуу цаг баримтлан хүргэлт хийж хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг бараа бүтээгдэхүүн хүлээн авдаг харилцагчдаас улирал бүр авч санал гомдлыг шуурхай шийдвэрлэх
- Зах зээлийн үнийн өсөлтөөс үл хамааран санхүүгийн чадавх нь тогтвортой байх, найдвартай аж ахуйн нэгж байгууллагатай гэрээгээр хамтран ажиллах
- Бэлтгэн нийлүүлэгч, харилцагч байгууллагуудыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдах авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалт хийсний үндсэн дээр сонгох
- Эцэг эхчүүдэд өөрийн нийлүүлдэг бүтээгдэхүүний сурталчилгаа, амталгааг тогтмол зохион байгуулах
- Цэцэрлэгүүдийн нярав, ахлах тогооч, туслах тогооч, нарт мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх, чадваржуулах, хууль тогтоомж, онолын мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг жил бүр хуваарийн дагуу зохион байгуулах

Стратеги-Нийгмийн хариуцлага

- Өндөр хариуцлагатай, хүнсний аюулгүй байдлыг хангасан, ард иргэд, үйлчлүүлэгчдийн итгэлийг хүлээсэн, мэргэшсэн манлай байгууллага болох.
- Байгууллагын Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрт заагдсан хөтөлбөр, арга хэмжээ бүрээр тухайн жилийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлэх, тайлагнах

Стратеги-Хүний нөөцийн хувьд

- Ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад байнга хамруулах, туршлага судлуулах,
- Чанарын удирдлагыг нэвтрүүлэх замаар удирдлагын тогтолцоог сайжруулж, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлснээр ажлын уялдаа холбоо, гүйцэтгэлийг сайжруулах.
- Хөдөлмөрийн норм, нормативыг тогтоож, хянаж боловсруулах.
- Ур чадвар, хөдөлмөрийн бүтээмжид тохирсон цалин, урамшууллын системийг бий болгох, ажилтнуудын тогтвортой үр дүнтэй, үр ашигтай ажиллах нөхцөл бүрдүүлж, нийгмийн асуудлыг үе шаттай шийдвэрлэх.

Стратеги-Шаардлагад хүрсэн хүнсний хангамж, аюулгүй байдал

- Тээвэрлэлтийн онцгой дэглэмийг хангасан тусгай зориулалтын чингэлэг бүхий хөргүүртэй, авто тээврийн хэрэгслээр хүнсний бүтээгдэхүүнээ төрөлжүүлэн түгээх
- Үйлчилгээний чанар, хугацаа, хариуцлагыг өндөржүүлэх
- Нэгдсэн удирдлага нь үйл ажиллагааны зардал хэмнэх
- Зах зээлийг өргөжүүлэх боломжийг судлах

- Үйлчилгээний бүтээмжийг дээшлүүлэх
- Орлого нэмэгдүүлэх ажлуудыг судлан санаачилж хэрэгжүүлэх


Стратеги-Бэлтгэн нийлүүлэлтийн хувьд

- Зах зээлийн үнийн өсөлтөөс үл хамааран санхүүгийн чадавхийн хувьд тогтвортой байх, үйл ажиллагаа нь тогтворжсон, найдвартай аж ахуйн нэгж байгууллагыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан хамтран ажиллах
- Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх, татан авах түгээлтийн авто машиныг бараа эргэлтийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх
- Хангамжийн түүхий эдийн бэлтгэлийн хүрээг өргөжүүлэх, нийлүүлэлтийн сүлжээний дэд бүтэц, үйлчилгээг ойртуулах
- Агуулах, оффисын шинэ барилга баригдсан тохиолдолд хүнсний бүтээгдэхүүн ангилах, савлах, боловсруулах үйл ажиллагааг шинээр нэвтрүүлэх

2. “ӨСВӨРҮЕ ХҮНС” ОНӨААТҮГ-ЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Байгууллагын удирдлагын бүтэц, зохион байгуулалт, орон тооны өнөөгийн байдал /хүснэгтээр/:

БАТЛАВ.
“ӨСВӨР ҮЕ ХҮНС” ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Г.МӨНХЗҮЛ



2.2. Удирдлагын бүтэц, зохион байгуулалт, орон тооны хүрэх түвшин:

№	Одоо ажиллаж байгаа бүтэц, орон тоо	Нэршил, ажил үүргийн хуваарь өөрчлөгдөх ажлын байр, орон тоо	Нэмэгдэх орон тоо	Нийт шинэ бүтэц, орон тоо
1.	Захирал -1	--	--	Захирал -1
2.	Менежер -1	--	--	Менежер -1
3.	Ерөнхий нягтлан бодогч -1	--	--	Ерөнхий нягтлан бодогч -1
4.	Тоцооны нягтлан бодогч-1	--	--	Тоцооны нягтлан бодогч -1
5.	Хүний нөөцийн менежер-1	Хүний нөөц, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Дотоод хяналтын ажилтан		Хүний нөөц, Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтан -1
6.	Эрүүл ахуйч -1	--	--	Эрүүл ахуйч -1
7.	Захирлын туслах, бичиг хэргийн ажилтан -1	Архив, бичиг хэргийн ажилтан		Архив, бичиг хэргийн ажилтан -1 (захирлын туслах)
8.	Агуулахын нярав -1	--	--	Агуулахын нярав -1
9.	Борлуулалтын нярав -3		Борлуулалтын нярав +2	Борлуулалтын нярав -5
10.	Түгээлтийн жолооч -4		Түгээлтийн жолооч +2	Түгээлтийн жолооч -6
11.	Ачигч -5	--	--	Ачигч -5
12.	Тоног төхөөрөмжийн механикч -1	Суурин ачигч		Суурин ачигч -1
13.	Үйлчлэгч -2	--	--	Үйлчлэгч -2
14.	Сахиул -1	--	--	Сахиул -1
15.			Хууль, дотоод хяналтын ажилтан +1	Хууль, дотоод хяналтын асуудал хариуцсан ажилтан -1
16.			Эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан +1	Эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан -1
17.			Касс, агуулахын нярав+1	Касс, агуулахын нярав -1
Нийт	24		+7	31

3. Худалдан авах ба нийлүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээ

3.1 Нийлүүлэх бүтээгдэхүүн:

2020-2023 онд Хан-Уул, Баянзүрх, Багахангай дүүргийн төрийн өмчит цэцэрлэгүүдийг эх орны томоохон үйлдвэрлэгчид, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендер сонгон шалгаруулсны үндсэн гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдээс /импортын бүтээгдэхүүнийг албан ёсны гэрээт борлуулагч, худалдаалах эрх бүхий байгууллагуудаас/ татан авч, хүнсний аюулгүй ажиллагааг мөрдлөг болгон эрүүл ахуйн шаардлага хангасан баталгаатай хүнсээр хангах.

3.2. Бараа бүтээгдэхүүн худалдан авах ба нийлүүлэхэд тавигдах шаардлагыг доорх үзүүлэлтээр хангах

а/ Хамтран ажиллагч түншүүдийг сонгоход баримтлах нөхцөл, журам, тухайн байгууллагатай хамтран ажиллах гэрээний хариуцлагыг дээшлүүлэх талаар.

1. Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх гүйцэтгэгчдийг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу тендер сонгон шалгаруулсаны дагуу гэрээ байгуулан ажиллана.
2. Ажлын байр, ажиллах хүч, агуулах сав, тээврийн хэрэгсэл нь Монгол Улсын зохих байгууллагаас тавигдсан стандарт шаардлагыг хангаж мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт гаргуулсан байна.
3. Нийлүүлэх хүнсний бараа материал нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй болохыг тогтоосон, хоол хүнсэнд тодорхой хугацаанд хэрэглэж болохыг зөвшөөрсөн улсын байцаагчийн дүгнэлт, итгэмжлэгдсэн лабораторид заавал баталгаажсан байх.
4. Шинэ хичээлийн жил бүрд, хичээл сургалт эхлэхээс 3-аас доошгүй хоногийн өмнө нийлүүлэх бараа бүтээгдэхүүнээ тус байгууллагын эрүүл ахуйч эмчийн нэг бүрчилсэн хяналттайгаар агуулахын няравт хүлээлгэн өгөх.
5. Тус байгууллагад бүтээгдэхүүн нийлүүлэхээр сонгогдсон компаниуд нь санхүүгийн хувьд чадавхитай байхаас гадна, бүтээгдэхүүнээ гэрээний үндсэн дээр зээлээр нийлүүлж, төлбөрийг 30 хүртэл хоногт багтаан нэхэмжлэн авах бололцоотой байх.
6. Тус байгууллагатай байгуулсан бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээ нь гэрээнд тавигдах стандарт нөхцөлийн дагуу хийгдэх бөгөөд, тусгайлсан нөхцөлүүдийг хоёр тал эцэслэн тохирсноор гэрээнд тусгана.

б/ Тус ОНӨААТҮГ -ын хүнсний бүтээгдэхүүн хадгалах агуулах, орчны стандарт

1. Тус байгууллагын бүтээгдэхүүн хадгалах агуулах нь Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газраас тогтоосон хүнсний барааны агуулах, техникийн ерөнхий шаардлага MNS 5364:2011 стандартыг хангасан зориулалтын вандан, тавиур бүхий битүү агуулах байна.
2. Барааны агуулахууд нь заавал төрөлжсөн байх бөгөөд түүнийг хаягжуулсан байхыг шаардана.
3. Агуулахууд нь түүнд тавигдах стандарт шаардлагуудыг хангасан байхаас гадна, өдөр тутам физик хэмжилт хийх зориулалтын багажтай байж, тухайн хэмжилт хийх

- зориулалтын багажтай байж, тухайн хэмжилтийг тусгайлсан дэвтэрт тогтмол тэмдэглэж байна.
4. Нэгдсэн агуулах нь хадгалах онцгой нөхцөл горим шаарддаг бараа хадгалах зориулалттай байна.
 5. Төрөлжсөн агуулах нь хадгалах онцгой нөхцөл горим шаарддаг бүлгийн бараа хадгалах зориулалттай байна. (халуун, хүйтэн, агаарын харьцангуй чийг тохируулах гэх мэт)
 6. Агуулахын эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, галын аюулаас урьдчилан сэргийлэх нөхцөл нь холбогдох стандартын шаардлага хангасан байна.
 7. Бараа буулгах гадна орчны хувьд талбайг цардсан, бараа буулгах тавцантай босго нь ачиж буулгах механизм, хүний үйл ажиллагаанд саад болохооргүй байна.
 8. Агуулах нь хадгалах барааны онцлогоос хамаарч байгалийн болон зохиомол агааржуулалт, гэрэлтүүлэг, халаалт, хөргөлт, дулаан чийг хэмжигч, өлгүүр, дэгээ, жин хэмжүүртэй байна.
 9. Ажиллагсдын ариун цэврийн өрөө, ажлын хувцасны өрөө болон амрах өрөөтэй байна.
 10. Барааг төрөлжүүлэн технологийн дагуу өрж цэгцтэй хураасан байна.

в/ Хүнсний бараа бүтээгдэхүүнийг хүлээн авах, тээвэрлэх стандартын нөхцлийг дээшлүүлэх талаар

1. Хүнсний бүтээгдэхүүний чанар орц, нормыг бүрэн шинжилж шалгадаг орчин үеийн техник, технологи нэвтрүүлнэ.
2. Хүнсний чанар, аюулгүй байдалд хяналт тавин үзлэг хийж, хүлээн авдаг эрүүл ахуйч, агуулахын нярав, бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд хүргэдэг борлуулалтын нярав, жолооч, ачигч нарын хүнсний бараа бүтээгдэхүүнтэй харьцах мэдлэг туршлагыг дээшлүүлэх, аль нэг шатны сургалтаар мэргэшүүлэх, давтан сургалтад хамруулах зэрэг ажлыг зохион байгуулна.
3. Бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчийн нэр тэмдэг, чанарын тохирлын тэмдэг зэрэг дугаар үйлдвэрлэсэн он, сар, өдөр, хадгалах болон борлуулах хугацаа, барааны цэвэр бохир жин, барааг хадгалах болон тээвэрлэх тусгай нөхцөл, кодын тэмдэглэгээ, хэрэглэх зааварчилгаа, тухайн бүтээгдэхүүний чанар байдлыг тодорхойлсон улсын байцаагчийн дүгнэлт зэргийг үндэслэн нэг бүрчилсэн ба хэсэгчилсэн үзлэг хийж хүлээн авна.
4. Хүнсний бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэхдээ заавал зориулалтын чингэлэг бүхий автомашинаар тээвэрлэх бөгөөд ингэхдээ гадна нянгийн бохирдол авч болзошгүй мах гэх мэт бүтээгдэхүүнийг бусад бүтээгдэхүүнтэй нийлүүлж ачсан тохиолдолд тэдгээрийг бусад бүтээгдэхүүнээс заавал тусгаарлах хаалт, хамгаалалт хэрэглэж тээвэрлэнэ.

г/ Байгууллагын хүний нөөцийн хөгжилд тавих шаардлага, мэргэжил ур чадвар, ажлын хариуцлага зохион байгуулалтыг сайжруулах талаар баримтлах бодлого.

1. Агуулахын болон борлуулалтын нярав нь тухайн ажлын шаардлагад нийцсэн мэргэжилтэй байх ба тэднийг давтан сургаж мэргэшүүлнэ.

2. Ажилтнуудын ажлын нөхцөлд тохирсон нэгэн жигд дүрэмт хувцсаар хангах ба энгэрийн тэмдэг эмблемтэй байна.
3. Ажилтнуудыг төрийн худалдан авах ажиллагаанд мэргэшүүлэх сургалт (А3 гэрчилгээ олгох) сургалтад ээлж дараатайгаар суралцуулах
4. Ажиллагсдыг хагас жилд нэгээс доошгүй удаа тогтмол эрүүл мэндийн үзлэгт хамруулж, эрүүл мэндийн үзлэгийн дэвтэрт зохих тэмдэглэгээг хийлгэж байна.
5. Хэрэглэгч үйлчлүүлэгчийн санал гомдлын хуудас ажиллуулж байна.
6. Бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанарын баталгаажуулалттай холбогдох баримт бичгийг иж бүрдлээр нь хадгалж, хэрэглэгч ба холбогдох албан тушаалтанд шаардлагатай үед танилцуулж байна.

д/ Ариун цэврийн дэглэмийг сайжруулах талаар баримтлах бодлого.

1. Байгууллагын хашаан доторх зам, талбай зүлгийг ариун цэврийн дүрмийн дагуу цэвэрлэж, ямагт цэвэр байлгана.
2. Байгууллагын агуулахаас ачилт, буулгалт хийсний дараа тогтмол хуурай болон нойтон цэвэрлэгээ хийж байна.
3. Байгууллагын агуулахад улирал бүр зохих мэргэжлийн байгууллагаар хортон шавьж, мэрэгч устгах ариутгалыг хийлгэж байна.
4. Агуулахын ариун цэвэр, барааны өрөлт, эмх цэгцтэй байдалд эрүүл ахуйч өдөр бүр тогтмол үзлэг хийж байгууллагын захиралд танилцуулж шаардлагатай тохиолдолд зохих шийдвэр гаргуулж байна.

4. ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

4.1 Хэрэглэгчийн судалгаа.

- Жил бүр харилцагч, үйлчлүүлэгч цэцэрлэг, ясли, эцэг эхчүүдээс өөрийн үйл ажиллагааны талаарх ойлголт, үнэлэлт, дүгнэлтийн байдалд өгөх үнэлгээний талаар хэрэглэгчийн судалгааг хийж, дүнг нэгтгэн үйл ажиллагаандаа анхаарч ажиллана.
- Үндсэн хэрэглэгч болох цэцэрлэг, яслийн гал тогоонд тавих үндсэн шаардлагад нийцсэн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлнэ
- Захиалгад нийцүүлэн шаардагдах тоо хэмжээгээр хэрэгтэй цагт нь найдвартай ханган нийлүүлэх бодлого баримтална.
- Зориулалтын хөргүүртэй тээврийн хэрэгслээр үйлчилдэг тул тээвэрлэх үеийн ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангагдана.

4.2. Бэлтгэн нийлүүлэгчийн судалгаа.

Үндсэн бэлтгэн нийлүүлэгчээр: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендер шалгаруулсны үндсэн дээр бэлтгэн нийлүүлэгч байгууллага, аж ахуйн нэгжүүд сонгогдож гэрээ байгуулна.

Гурван талт гэрээгээр харилцагчид: Талх, нарийн боов болон сүү, сүүн бүтээгдэхүүн зэрэг түргэн гэмтэж, муудах эрсдэлтэй, технологийн өндөр горим шаарддаг хүнсний

бүтээгдэхүүнүүдийг үндэсний томоохон үйлдвэрлэгчдээс, эрүүл ахуйн шинжилгээ, баталгаажилт, хүүхдийн хоолны шим тэжээл, илчлэг байдлыг харгалзан гэрээ байгуулсны үндсэн дээр нийлүүлэлт хийн ажиллана.

Бэлтгэн нийлүүлэгчийн сонголтыг оновчтой зохион байгуулан найдвартай түнштэй болоход хүснэгтэд заасан шалгуур үзүүлэлтүүдийг ашигладаг.

Хүснэгт 1. “Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ -ын SWOT шинжилгээний матриц

Дотоод хүчин зүйлс		Гадаад хүчин зүйл	
Давуу тал (S)	Сул тал (W)	Боломж (O)	Аюул (T)
<ul style="list-style-type: none"> • Эрэлт нийлүүлэлтийн тогтвортой харьцаа, чанартай бүтээгдэхүүн нийлүүлдэг байнгын найдвартай харилцагч түншүүд • Санхүүгийн баталгаатай эх үүсвэр • Захиалгад тулгуурлан үйлдвэрлэлээ явуулдаг учир зах зээл хайх шаардлагагүй • Цэцэрлэгийн эрэлтэд нийцүүлэн стандартын дагуу үйлдвэрлэсэн бэлдэцээр ханган нийлүүлдэг. • Зах зээлийн багтаамж ихтэй. Цэцэрлэг, хэрэглэгчийн эрэлт, байгууллагын хүчин чадал нэмэгдэхийн хэрээр зах зээл нэмэгдэх төлөвтэй байгаа • Үйлдвэрлэл, борлуулалтын олон жилийн туршлагатай • Тодорхой дадлага туршлагатай боловсон хүчинтэй • Үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлэхэд шаардлагатай дэд бүтэц болон үндсэн хөрөнгөтэй. 	<ul style="list-style-type: none"> • Санхүүжилтийн хувьд үйлчлүүлэгчийн эдийн засаг хязгаарлагдмал, санхүүгийн чадавх сул, • Түншүүдийн итгэлцэл, зээлийн тогтолцоонд тулгуурлан үйл ажиллагаа явагддаг • Түүхий эдийн үнэ тогтворгүй, байнгын өсөн нэмэгдэх хандлагатай. • Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчдийг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу сонгон шалгаруулдаг тул хэрэглэгчдийн хүссэн бүтээгдэхүүн бүрийг сонгон нийлүүлэх боломжгүй 	<ul style="list-style-type: none"> • Үйлдвэрлэл, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн үйл ажиллагааг төрөл болон нэр төрлөөр нэмэгдүүлэх боломжтой • Ажилтнуудын орон тоо нэмж цалинжуулах, машин механизмыг өөрийн хуримтлагдсан ашгаар нэмэгдүүлэх • Бэлдэцийн чанар сайжруулж чадвал хэрэглэгч нь бэлэн байгаа • Шинээр ажиллах боловсон хүчнээ өөрийн байгууллагад ажиллуулан дадлагажуулах бүрэн боломжтой • Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг амжилттай өргөжүүлж төсөвт их хэмжээний орлого бүрдүүлэх боломжтой. 	<ul style="list-style-type: none"> • Бэлтгэн нийлүүлэгчээс түүхий эдээ авдаг учир хараат байдал үүсэх магадлалтай. • Байгалийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр малын гоц халдварт өвчин дэгдэх, онцгой дэглэм тогтоогдсон тохиолдолд бүтээгдэхүүний тасалдал үүсэх магадлалтай

4.3. Түүхийн эдийн хангамжийн эх үүсвэрийн судалгаа. /Түүврээр/

д/д	Шалгуур үзүүлэлт	Байгууллага			
		“Талх чихэр” ХК	“Грийн импекс” ХХК	“АПУ Дэйри”ХК	“Эрдэнэ Энх Трейд” ХХК
1	Чанар	+	+	+	+
2	Бүтээгдэхүүний онцлог	+	+	+	+
3	Орц, жор	+	+	+	+
4	Үнэ	+	+	+	+
5	Хангамж, санхүү	+	+	+	+
6	Бэлтгэн нийлүүлэгчдийн байршил	-	-	+	+
7	Тээврийн зардал	-	-	+	+
8	Тээвэрлэлтийн хугацаа	-	-	+	-
9	Бэлтгэн нийлүүлэгчийн найдвартай байдал	+	+	+	+
10	Хөнгөлөлтийн нөхцөл	+	+	+	+

Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн үнийн дүнгийн хэмжээнээс хамаарч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендер шалгаруулсан болно. Эдгээр аж ахуй нэгжүүдтэй манай байгууллага гэрээнд заасан хамтын үүргээ 2 тал аль аль нь хариуцлагатайгаар биелүүлж ирсэн. Эдгээр байгууллагатай хамтран ажилснаар бид дараах давуу талыг бий болгосон. Үүнд:

- ✓ Баталгаатай бараа бүтээгдэхүүн
- ✓ Тээвэрлэлтийн хугацаа богино
- ✓ Тээврийн зардал хэмнэгдсэн
- ✓ Тогтвортой ажиллагаа

5. МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1 Маркетингийн стратеги

“Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ-ын бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний эрэлт хэрэгцээ ямар байгааг нөлөөлөгч хүчин зүйлээр тооцоолох, хэрэгжүүлэх арга хэмжээг урьдчилан тодорхойлоход энэхүү маркетингийн төлөвлөгөөний зорилго оршиж байгаа бөгөөд зорилгод зах зээл түүний багтаамж, байршил, дотоод хэсэглэл, үнэ, маркетингийн стратеги зэргийг тодорхойлно.

“Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ-ын зорилго, зорилтуудын хүрээнд дотоод боломж, төлөвлөгөөт тооцооны ашигтай хувилбарыг үндэслэн Баянзүрх, Хан-Уул, Багахангай дүүргүүдийн цэцэрлэгүүдийг чанартай хүнсээр хангах үйл ажиллагаа явуулах ба шинэ бүтээгдэхүүнийг нийлүүлэх чанараа сайжруулах стратегитай хослуулах нь зүйтэй байна. Маркетингийн стратегид тусгагдсанаар бараа бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээний захиалгын дагуу бараагаар хангахад чиглэгдсэн бодлого боловсруулж баримтлах нь зүйтэй байна.

Үйлчлүүлэгчийн төлөв байдлын хувьд судалж үзэхэд, чанартай, эрүүл ахуйн шаардлага хангасан, аюулгүй байдлын хувьд баталгаатай витаминлаг хүнсээр хангуулах сонирхолтой байгаа бөгөөд өөрсдийн төсөв мөнгөтэй уялдуулан ихэнх нь зээлийн тогтолцоонд хамрагдах эрмэлзэлтэй байна..

5.2. Бүтээгдэхүүний бодлого

Тус байгууллагад нийлүүлэгдэж буй нийт бараа бүтээгдэхүүний 80 хувийг үндэсний үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн эзлэх бөгөөд энэ хувь хэмжээг нэмэгдүүлэх, хүүхдийн насны онцлогт тохирсон витамин амин дэмээр баялаг, эрүүл ахуйн шаардлага хангасан чанартай хүнсний бараа бүтээгдэхүүнээр хангаж хяналтын тогтолцоог сайжруулна

Хүүхдийн насны онцлогт тохирсон шимт бодисын хэрэгцээг хангасан эрүүл зөв бүтэцтэй бүтээгдэхүүнээр цаг алдалгүй түргэн шуурхай үйлчлэн Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуульд заасны дагуу “Мал амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам”-ыг хэрэгжүүлэх, түүнийг үндэслэн бүтээгдэхүүний нийлүүлэлт хийх бүрд мэргэжлийн хяналтын байгууллагын улсын байцаагчийн дүгнэлт, эсхүл магадлан итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичиг, дагалдах санхүүгийн баримтыг хавсаргаж, эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнийг захиалгын дагуу бэлтгэн нийлүүлдэг байна

5.2. Үнийн бодлого

Зах зээлийн үнийн судалгааг Нийслэлийн Статистикийн газрын цахим хуудас /<http://ubstat.mn/> болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээллийг үндэс болгодог. Мөн байгууллагын зүгээс нийслэлийн томоохон хүнсний захуудаас улиралд нэгээс хоёр удаа үнийн харьцуулалтын судалгаа гаргаж үнийн бодлогодоо тусган ажилладаг

Үнийн бодлогыг тодорхойлохдоо жил бүр нийслэлийн Засаг дарга, НӨАУГ-тай байгуулах контрактаар батлагдаж, төлөвлөсөн орлогыг бүрдүүлэх, зорилтот түвшинг биелүүлэх үүднээс орлогыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн ажил үйлчилгээний чанарыг сайжруулах, санхүүгийн чадавхийг дээшлүүлэх зэрэгт чиглүүлэх шаардлагатай байгаа бөгөөд энэ нь зорилтод зах зээл, бүтээгдэхүүний чанарын түвшинг тодорхойлох, байр сууриа бэхжүүлэх, боломжит хэмжээгээр хуримтлал бий болгох зэрэг нөхцөлийг бүрдүүлэх юм. Үүнтэй холбоотойгоор бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг зах зээл дээрх үнийн огцом савалгаанд авталгүй, үнийн тогтвортой бодлого барихын зэрэгцээ, чанарын түвшинг дээшлүүлэх, үйлчлүүлэгчдийнхээ итгэлийг алдахгүй байхад оршино.

5.3. Борлуулалтын төлөвлөгөө

Стратеги төлөвлөгөөний зах зээлтэй харилцах хамгийн чухал үзүүлэлт бол бүтээгдэхүүний борлуулалт буюу хэзээ, хаана, хэний хэрэгцээнд хэдий хэмжээгээр ямар чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд гаргах тухай асуудал байдаг бөгөөд үүнийг борлуулалтын төлөвлөгөөгөөр зохицуулна. Тухайлбал: Цэцэрлэгүүдээс ирсэн захиалгын дагуу ямар тоо хэмжээгээр бэлтгэх, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх зардлыг хэмнэх, төлөвлөсөн хугацаанд эрэлтэд нийцүүлэн зорилгот зах зээл, түүний хэсгүүдэд чанар сайтай хэрэгцээт бүтээгдэхүүнийг хэрэглэгчийн таашаалд нийцүүлэн нийлүүлж, борлуулалтын төлөвлөсөн орлогыг баталгаатай олох нөхцөл бололцоог хангахад оршино. Борлуулалтын төлөвлөгөө нь байгууллагын төлөвлөгөөт хугацаанд гүйцэтгэх үйл ажиллагаа нь гол үзүүлэлтүүд болох тул түүнийг үндэслэн төлөвлөгөөний бусад хэсгүүдэд өөрчлөлт тооцоо хийдэг. Мөн эндээс гарах үнэлэлт, дүгнэлт нь стратеги төлөвлөгөөний гол үр дүнг илэрхийлэх чухал үзүүлэлт болно.

Борлуулалтыг идэвхжүүлэх арга хэмжээ: Харилцагч нийт цэцэрлэг, яслиудад нийлүүлэгдэж буй бүтээгдэхүүн болон шинээр нийлүүлэх бараа бүтээгдэхүүний танилцуулга, сурталчилгааг тогтмол хийнэ. Хамгийн гол асуудал нь борлуулалтыг хүчтэй идэвхжүүлэх үр ашигтай арга хэмжээг сонгон авах явдал юм. Борлуулалтыг идэвхжүүлэх арга хэмжээ гол төлөв эдийн засгийн шинжтэй байх бөгөөд чанартай, сайн чанарын бүтээгдэхүүнийг зах зээлийн бөөний үнээр найдвартай хангах. Нийлүүлэгч байгууллагын ажлын байр, бүтээгдэхүүн үйлдвэрлэх явцтай цэцэрлэгүүдийн төлөөлөлтэй хамт танилцах.

Борлуулалтын дараах үйлчилгээ: Цэцэрлэгүүдтэй байнгын харилцаа холбоотой байдаг. Иймд бүтээгдэхүүн нийлүүлсний дараа доорх үйлчилгээний хэлбэрүүдийг өргөн хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Үүнд:

- Цэцэрлэгүүдэд нийлүүлэгдсэн бүтээгдэхүүний хадгалалт, агуулахын ариун цэвэр, эрүүл ахуйн талаар зөвлөгөө, мэдээлэл газар дээр нь очиж өгч ажиллах
- Цэцэрлэгүүдэд нийлүүлэгдэж буй бараа материал чанар, сэтгэл ханамжийн шаардлага хангаж байгаа эсэх талаар санал асуулга явуулах
- Цэцэрлэгүүдийн хүсэл сонирхлын хүндэтгэж, чанар, эрүүл ахуйн доголдолтой бараа материалыг татан авдаг байх

Худалдан авах ажиллагааны талаар:

- Тухайн жилд хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх гүйцэтгэгчдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулсны үндсэн дээр сонгон шалгаруулж ажиллана. Сонгон шалгаруулалтын урилга, зар мэдээллийг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, төрийн худалдан авах ажиллагааны цахим хуудас болон олон нийтийн цахим сүлжээ, өөрийн байгууллагын цахим хуудаснуудад тус тус тухай бүрд нь байршуулж, олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байдлаар хүргэнэ.

5.4 Хяналтын механизм

- Байгууллагын дотоод хяналт, шалгалт зохион байгуулах журмын дагуу жил бүр төлөвлөгөө гарган, түүний дагуу хийх дотоодын хяналт шалгалтыг эрчимжүүлж, тогтворжуулах
- Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд өдөр тутамд захирал хяналт тавин ажиллана. Санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгдөг Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас жил бүрийн төгсгөлд хийх ажлын хэсгийн шалгалт, Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар, Татварын байгууллага, санхүүгийн болон хөндлөнгийн, дотоод аудит, мэргэжлийн хяналтын байгууллагууд тус тус хөндлөнгийн хяналт, шалгалтад зохих хугацаанд нь хамрагдаж ажиллана.